

“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ

2013 оны 7 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Цог

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү, Д.Батцогт, Н.Батцэрэг, С.Бямбацогт, Р.Гончигдорж, С.Дэмбэрэл нар Монгол Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 40 дүгээр тогтооолоор баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж, 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Төсөл санаачлагчид төслийн үзэл баримтлалдаа өнөөгийн хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгмийн зарчимд нийцүүлэн Монгол Улсын төрт ёсны уламжлалыг шинэчлэн хөгжүүлэх, Төрийн тэргүүн ард түмэндээ хүндэтгэл үзүүлэх зорилгоор монгол хүний эх оронч үзлийг хөгжүүлэх, төр улсаараа бахархах, тусгаар тогтнолын үнэ цэнийг мэдрүүлэх ач холбогдолтой гэсэн үндэслэлийг тусгаж энхүү тогтоолын төслийг боловсруулжээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг 2013 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат “Ерөнхийлөгчийн тангараг өргөх үйл ажиллагааг Их эзэн Чингис хааны хөшөөний урд явуулах нь ард түмнээ хүндэтгэж, нээлттэй явуулж байгаагийн илрэл юм” гэж байр сууриа илэрхийлэв.


“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх нь дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



А.БАКЕЙ